# Байгууллагын бүтэц, үйл ажиллагаа

## Хэрэгцээ ба хангалт

# Агуулга

- Байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх мэдэл, үүрэг

- Байгууллагын гүйцэтгэх бүх үйл ажиллагаа, үүргүүдийг нарийн тодорхойлохын ач холбогдол

- Чанарын менежерийн гүйцэтгэх үүрэг

# Байгууллагатай холбоотой нэр томьёо

## Байгууллага

- Үүрэг, эрх мэдэл, харилцааг нарийн тогтоож, зохион байгуулсан бүлэг хүмүүс болон тасаг, нэгжүүдийн цогц

## Байгууллагын бүтэц

- Хүмүүсийн үүрэг болон тэдний хоорондын харилцааг нь нарийн, дараалалтай тогтоосон зохион байгуулалт

# Эрх мэдэл ба үүрэг (1)

- Байгууллагын бүх ажиллагсад өөрсдийн харъяалал, захирах, захирагдах дараалал, эрх мэдэл, үүргээ тодорхой мэддэг байх шаардлагатай.
- Ажиллагсдад тодорхой эрх мэдэл олгохгүйгээр зөвхөн үүрэг хариуцуулж болохгүй.
- Байгууллагын үйл ажиллагааны зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц зохион байгуулалтын зургийг гаргаж, мэдээлэх ёстой.

# Эрх мэдэл ба үүрэг (2)

- Байгууллагын тасаг нэгжүүд тус тусдаа салангид бус, нэгмэл байдлаар ажиллах нөхцлийг хангасан бүтэц, зохион байгуулалттай байх ёстой.
- Байгууллагын бүтэц, зохион байгуулалтын зургийг гаргаж баримтжуулах шаардлагатай.
- Чанарын менежер нь тодорхой үүрэг гүйцэтгэж байгаа хүмүүсээс ангид, биеэ даан ажиллах ёстой.

# Бүтэц, зохион байгуулалтын зургийн жишээ (1)



# Бүтэц, зохион байгуулалтын зургийн жишээ (2)



# Ажиллагсад ба байгууллага (1)

- Байгууллагынхаа үүргийг ажиллагсад тодорхой мэддэг байх ёстой.
  - Тус байгууллага ямар ажил гүйцэтгэдэг вэ?
  - Тус байгууллагын үйлчлүүлэгчид нь хэн бэ?

# Ажиллагсад ба байгууллага (2)

- Байгууллагын бүтэц зохион байгуулалт, гол зорилго зорилт тодорхой байвал, бүх ажиллагсад нь гүйцэтгэх үүргээ бүрэн ойлгож чадна.
  - Хэнд захирагдаж, ажлаа тайлагнах вэ?
  - Ямар ажил гүйцэтгэх вэ?
  - Яагаад энэ ажлыг хийдэг вэ?
  - Ажил, үүргээ буруу гүйцэтгэснээс ямар үр дагавар үүсэх вэ?
  - Тасаг нэгжүүд хэрхэн харилцан уялдаж, ажиллах вэ?

# Хэрэгцээ ба хангалт

- Эмч нар онош тавьж, эмчилгээний төлөвлөгөө боловсруулна.
- Заалт ба шийдвэр гаргана.
- Сувилагч нар эмчилгээний төлөвлөгөөг хэрэгжүүлж, хянахад оролцдог,
- Эмч, сувилагч нар эмчилгээний төлөвлөгөөг өвчтөнд танилцуулж, зөвшөөрөл авна (таниулсан зөвшөөрөл)

# Хэрэгцээ ба хангалт

- Эмнэлгийн лаборатори нь цусны бүлэг, тохироо үзэж, дархлалын шинжилгээ хийнэ.
- Онош тавьж, сэлбэлтийн үр дүн гарах хүртэлх бүр үе шатыг баримтжуулах (цусны сонор сэрэмж)
- Ардчилсан болон хязгаарлагдмал, цөөн нэр төрлийн дэглэм

# Хэрэгцээ ба хангалт

- Цусан бүтээгдэхүүнийг эмчилгээнд хэргэлэхдээ зөвхөн заалтаар зохистой хэрэглэх
- Эмнэлгийн цус сэлбэлтийг зохицуулах зөвлөл нь:
  - Цус сэлбэх бодлого, стратеги
  - Нотолгоонд суурилсан эмнэлзүйн удирдамж
  - Бичиг баримтын хяналт
  - Урвал хүндрэлийн мэдээлэл
  - Ажиллагсдын сургалт
  - Мэдээлэл цуглуулах, үнэлэх

# Хэрэгцээ ба хангалт

- Зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд эмнэлзүйн харилцан уялдаа холбоо дээд зэргийн байх
- Цус ханган хийлүүлэх байгууллага, эмнэлгүүд харилцан холбоотой байх
- Цус сэлбэлтийн мэргэжилтний зөвлөгөө-тогтмол байх

# Хэрэгцээ ба хангалт

- Дундаж зарцуулалтанд үндэслэн цус цусан бүтээгдхүүний хангалт  (статистик мэдээ/SPC)
- Хүйтний хэлхээний хяналт
- Тохирсон төлөвлөлт
- Төрөл
- Урвал хүндрэл



# Чанарын менежер

- Удирдлагаа төлөөлнө.
- Байгууллагын даргатай шууд харилцаж, мэдээлнэ.
- Байгууллагын үйлдвэрлэл буюу үзүүлдэг үйлчилгээнд оролцохгүй, хянах үүрэгтэй.
- Чанарын тогтолцоог нэвтрүүлж, тогтмолжуулах үүрэг хүлээхийн зэрэгцээ тодорхой эрх мэдэл эдлэнэ.

# Чанарын менежерийн үүрэг

- Чанарын тогтолцоог нэвтрүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, уг тогтолцоог хэвшүүлэх
- Цусны албаны бүх ажиллагсдыг чанарын хөтөлбөрт хамруулах
- Байгууллагад чанарын соёлыг хөгжүүлэх
- Ажиллагсдад зориулж чанарын тогтолцооны талаар сургалт зохион байгуулах
- Байгууллагын тасаг нэгж бүрд чанарын тогтолцоог нэвтрүүлэх  ажлыг дэмжих, зөвлөн туслах

# Гол ойлголт (1)

- Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг нарийн тогтоох нь үйл ажиллагааг саадгүй хэрэгжүүлэхэд маш чухал ач холбогдолтой.
- Байгууллага бүхэн бүтцээ албан ёсоор батлуулсан байх шаардлагатай.
- Байгууллагын дотор эдлэх эрх мэдэл, гүйцэтгэх үүргийг тодорхойлсон байх ёстой.
- Байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлэхийн тулд бүтэц, зохион байгуулалтыг улам боловсронгуй болгох ёстой.

# Гол ойлголт (2)

- Чанарын тогтолцоог нэвтрүүлэх хэвшүүлэх, үйл ажиллагааг зохицуулах үүргийг чанарын менежер хүлээдэг.
- Чанарын менежер аль ч тасаг нэгжид харъяагдахгүй биеэ даан ажиллах ёстой.
- Чанарын менежер байгууллагынхаа удирдлагатай шууд харилцаж, мэдээлдэг байх ёстой.
- Цусны алба харилцан уялдааг ханган ажиллах